



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/10

Амардалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2023 оны Улс, аймаг, сумын аварга малчид болон сумын шилдгүүдийг шагнах шагналын зардалд зориулж 2,785,000 төгрөг, Сумын харъяат 80 аас дээш насны ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зардалд 1,375,500 нийт 4,160,500 (Дөрвөн сая нэг зуун жаран мянга таван зуун) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсугай.

2.Дээрх зардлыг журмын дагуу гаргаж хяналт тавьж холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  М.БАЯРСҮХ



Сумын Засаг даргын 2024 оны 01 сарын 26-ний
өдрийн А/10 дугаар захирамжийн хавсралт

Шагнал урамшуулал	Мөнгөн дүн
Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг	1375500
Улс, аймгийн аварга малчид болон 2023 оны сумын шилдэгүүдийн шагналд	2785000
Нийт мөнгөн дүн	4160500